

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Эдийн засаг, хөгжлийн яамны хэрэгжүүлэхээр хяналтад авсан Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийн 2025 оны жилийн эцсийн хэрэгжилт болон үр дүнг тодорхойлж, хэрэгжилтийг сайжруулахад шаардлагатай дүгнэлт, зөвлөмж боловсруулах, тайланг нэгтгэн хэлэлцүүлэх, удирдлагыг мэдээллээр хангахад оршино.

Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 03-ний өдрийн 183 дугаар тогтоолын хавсралт "Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журам"-ын "6.2 дахь заалтыг баримтлан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийг үнэлэх аргачлалаар хяналт-шинжилгээг хийж гүйцэтгэсэн.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд 2025 оны жилийн эцсийн байдлаар:

- Монгол Улсын хууль 9 шийдвэрийн 35 заалт;
- Улсын Их Хурлын тогтоол 31 шийдвэрийн 72 заалт;
- Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол 15 шийдвэрийн 24 заалт;
- Ерөнхийлөгчийн зарлигийн 5 шийдвэрийн 6 заалт;
- Засгийн газрын тогтоол 75 шийдвэрийн 123 заалт;
- Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 69 шийдвэрийн 180 заалт;
- Засгийн газрын албан даалгавар 7 шийдвэрийн 73 заалт;
- Ерөнхий сайдын захирамж 12 шийдвэрийн 12 заалт;
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн 2 шийдвэрийн 2 заалт;
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдааны тэмдэглэл 1 шийдвэрийн 1 заалт;

Нийт 226 шийдвэрийн 528 заалтын хэрэгжилтийг тайлагнахаар Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд оруулсан.

Гурав. Дүгнэлт

Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 183 дугаар тогтоолын хавсралт "Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журам"-ын дагуу хийгдсэн Хяналт-шинжилгээний дүнгээр 456 заалт бүрэн хэрэгжсэн, ахиц гарсан 13, тодорхой үр дүнд хүрсэн 11, удаашралтай /эрчимжүүлэх шаардлагатай/ 0 заалт, хэрэгжээгүй 0 заалт, хугацаа болоогүй 48 заалт буюу нийт 528 заалтын дундаж үнэлгээ 97.5% хувьтай байна.

Дөрөв. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ / Зөвлөмж /

1. “Хэрэгжилтийн тайланг цахим санд оруулахдаа тухайн зорилт, арга хэмжээ, заалтын хүрсэн үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаан /нотлох баримт/ хавсралтын хамт ирүүлэх;
2. Газрын хурлаар арга хэмжээ тус бүрийн гүйцэтгэлийг хэлэлцэж тайлан, мэдээллийг нэгтгэж цаг хугацаанд нь албажуулж ирүүлэх;
3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн “Хэрэгжээгүй болон Хугацаа болоогүй” хэрэгжилттэй арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх;
4. Арга хэмжээ, хууль тогтоомжийн үр дүнг тайлагнахдаа зорилтот түвшинд хүрсэн эсэх болон шийдвэрлэгдсэн гол ажлыг оновчтой, товч тодорхой, үг үсгийн алдаагүй байдлаар бичих.